

Ёочиндох аргын томьёоллыг шинжих нь

Самдансүрэнгийн Уранбилэг^{1,*}
Цэрэнбалжирын Цэвэгсүрэн¹

¹ Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль, Улаанбаатар, Монгол Улс
ORCID: <https://orcid.org/0009-0008-2914-8945>
ORCID: <https://orcid.org/0009-0008-7598-8769>
*Холбоо барих зохиогч: huiia_4@yahoo.com

Хураангуй: Аливаа үндэстэн, угсаатны уламжлалт ая аялгуу, эгшиглэгээний онцлог нь тухайн улс орны хөгжмийн бүтээлүүдэд шингэн тусгалаа олсон байдаг. Үүнийг хөгжимдүүрээр илэрхийлэх арга барил, онцлог, төрөл зүйлс нь цохилго бөгөөд үүнийг орчин цагт дуулах, хөгжимдөх урлагт холбогдох нэршил, ая, аялгууг дуурсгах үеийн нугалаа, хугалаа, чимэглэл хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нь хөгжимдөх аргын үндсэн аргуудад (үлээх, цохих, товших, хавирах г.м) тулгуурлан донж маяг, онцлогоороо хөгжим тус бүрд олон янзаар төрөлжин ангилагдаж, томьёологдсон байдаг.

Тэгвэл бидний энэ удаагийн судалгааны зорилго бол, ёочиндох аргын тодорхой горим, тогтолцоог буй болгоход оршино.

Энэхүү судалгааны үр дүнд ёочиндох аргын 65 төрөл зүйлийг тодруулан тодорхойлж, үүнийг хөгжимдөх үйлээр нь цохих, татах, дарах, чөлөөт хэмээн ангилан, онцлогоор нь 18 төрөлжүүлж, нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээг шинээр болон шинэчлэн оноож томьёолсон.

Түлхүүр үгс: *хөгжим, хөгжимдүүр, хөгжимчин, нэршил, тэмдэглэгээ, ангилал*

Analysis of the formulation and system of the play dulcimer method

Uranbileg Samdansuren^{1,*}
Tsevegsuren Tserenbaljir¹

¹ School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0008-2914-8945>

ORCID: <https://orcid.org/0009-0008-7598-8769>

*Corresponding author: huia_4@yahoo.com

Abstract: The characteristics of the traditional tunes and sounds of any nation and ethnic group are fluidly reflected in the musical works of that country. The methods, features, and types of musical expression of this are percussion, and it is defined as the fold, fracture, and ornamentation of the modern singing and musical arts, as well as the folds, breaks, and decorations of imitating the melody. Based on the basic methods of playing music (blowing, hitting, tapping, strumming, etc.), it is classified and formulated in many different ways for each type of music.

Therefore, the purpose of our current research is to create a specific method and system of play dulcimer.

Within the framework of the main objective, the following objectives were proposed. It includes: Work with sources and materials related to play dulcimer method formulations;

Analyzing the rhythmic movement of play dulcimer method in relation to the artists, works and repertoire;

Clarifying the rhythmic movement of the play dulcimer method: As a result of this research, 59 types of play dulcimer methods were clearly identified, divided into 4 categories according to their musical actions: hitting, pulling, pressing, and free, 18 types, and each type was classified into 59 items according to their characteristics, and new and newly assigned terms and symbols were formulated.

Keywords: *music, instrument, musician, classification, genre, nomenclature, notation*

Оршил

Монгол үндэстний соёл сэтгэлгээ, уран сайхны тусгал болсон хөгжмийн урлаг тэр дундаа үндэстний гэх тодотголтой, өвөрмөц онцлог бүхий хөгжимдүүрүүд нь эрт үеэс уламжлагдах явцдаа баялаг түүхийг бүтээсээр ирсэн. Үүний адил манай үндэстний хөгжмийн урлагт онцгой байр суурьтай, өвөрмөц нэгэн хөгжимдүүр бол “ёочин” юм.

Ёочин нь манай үндэстний хөгжмийн урлагт олдмол уламжлалаар уламжлагдаж ирсэн бөгөөд түүний гарал үүсэл, тархац нутаг, ангилал, төрөл зүйлс, хийц бүтэц, хөгжимдөх үйл нь монголын зэмсэг судлалын хүрээнд тодорхой түвшинд судлагдсаар байна.

Ёочиндох аргын томьёолол 1969 оноос эхтэй бөгөөд үүнд цохин хөгжимдөх үйлийн баруун, зүүн гарын хөдөлгөөнийг дөрвөн хувилбарт тэмдэглэсэн бол 1984 онд нь дээрх дөрвөн хувилбартай санал нэгдэн, нэг буюу хос эгшгийг тасралтгүй давтамжаар асар хурдтай, жигд үргэлжлүүлэн цохих үйлийн тэмдэглэгээг тэмдэглэсэн байдаг. Үүнээс хойш ёочиндох аргыг илүү дэлгэрэнгүй, нарийвчлан томьёолох үйлс 2006 оноос эхтэй бөгөөд үүнийг сургалт хөтлөгч, судлаач багш, уран бүтээлчид, хөгжмийн зохиолчид бүтээлээрээ дамжуулан өнөөг хүртэл эрчимтэй хийсээр ирсэн. Бид үүнд холбогдох эх хэрэглэгдэхүүнүүдтэй ажиллан, томьёоллын байдлыг ерөнхийлөн авч үзэхэд нэршил, тэмдэглэгээний хувьд санал нэгдсэн нь байвч, хувь судлаачийн өөр өөрийн үзэл баримтлалд тулгуурласан олон янзын томьёолол нь биднийг ёочиндох аргыг нэгдмэл цогц байдлаар тодорхойлж, томьёолох судалгааг эхлүүлэх үндэслэл болсон юм.

Дээрх судлагдахуунуудын чухал хэсэг болох ёочиндох арга барилын тодорхойлолт, томьёоллын асуудлыг түүний түүхэн явц, эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан задлан шинжилж, нэгтгэн дүгнэж, ангилан төрөлжүүлсэн үр дүнг судалгааны эргэлтэд оруулах нь энэ чиглэлийн судалгааны царааг өргөжүүлэх, эх хэрэглэгдэхүүнийг баяжуулах, судлаачдад чиг баримжаа олгох чухал ач холбогдолтой.

Энэхүү судалгааны шинэлэг талыг дараах байдлаар авч үзэв. Үүнд:

- ✓ Ёочиндох аргын цохилго хөдөлгөөнийг хөгжимдөх үйлтэй уялдуулан тодорхойлж, ангилан төрөлжүүлснээрээ
- ✓ Ёочиндох аргын цохилго хөдөлгөөнийг анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх хэрэглэгдэхүүнийг ашиглан харьцуулан судалсны үр дүнд нэгдсэн томьёоллыг буй болгосноороо
- ✓ Өмнө томьёологдоогүй арга, цохилгод шинээр нэршил, тэмдэглэгээ оноох санал дэвшүүлснээрээ

Судалгааны арга зүй

Хөгжлийн явцад ёочингийн хөгжимдөх арга, цохилго хөдөлгөөнийг томьёолж эхэлсэн нь 1969 он ба үүнийг судлаачид өнөөг хүртэл зогсолтгүй үргэлжлүүлсээр ирсэн байдаг. Гэвч тухайн томьёололтой холбогдох эх хэрэглэгдэхүүнүүдтэй ажиллан ажиглалт, харьцуулалт хийн үр дүнд нь ёочиндох арга, цохилго хөдөлгөөнийг тодорхой түвшинд, цогц, нэгдмэл байдлаар томьёолсон нь хараахан үгүйг илрүүлж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, загварчлалын аргад тулгуурлан асуудлыг шийдэх, боловсруулах зарчим, арга зүйг тус тус ашигласан.

Судалгааны үр дүн

Аливаа нэг бүтээлийн ая, аялгууны нугалаа, хугалаа, чимэглэлүүдийг хөгжимдүүр тус бүрийн онцлогт тулгуурлан нэршил оноохоос гадна, дүрст болон тоон тэмдэг, тэмдэглэгээгээр тэмдэглэсээр ирсэн. Энэ нь тухайн бүтээлийг хэрхэн хөгжимдөх талаарх мэдээллийг агуулсан бичлэг юм.

Ёочингийн түүхэн үйл явцаас үзэхэд, хөгжимдөх аргын нэршил, тэмдэг, тэмдэглэгээний асуудалд судлаач багш, уран бүтээлчид судалгаа, сурах бичиг, уран бүтээл, урын сангаар дамжуулан үеийн үед анхаарлаа хандуулсаар ирсэн байдаг. Энэ нь тэдний хөгжимдөх арга барил, дадлага, туршлага, мэдлэг оюунд

түшиглэн боловсруулсан нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээг боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулсаар байна.

Энэхүү судалгааны үр дүнд бид ёочиндох аргыг түүнд зориулсан уран бүтээл, урын сан, судалгааны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан шинжиж дараах байдлаар авч үзэж байна.

Ёочингийн түүхэн хөгжлийн явцаас үзэхэд, ёочиндох арга, цохилго хөдөлгөөнд нэршил, тэмдэглэгээ оноох анхны алхмыг 1969 онд А.Чулуунбат нь “Ёочиндож сурья” бүтээлдээ тусгасан бол үүнээс хойш үе үеийн судлаач багш, уран бүтээлчид, хөгжмийн зохиолчид бүтээлүүддээ өөр өөрийн онол, практик, туршлагад тулгуурлан томьёолоор ирсэн. Эдгээр нь ёочиндох аргын нэгдсэн томьёоллыг боловсруулах үйлсэд ач холбогдол бүхий чухал хэрэглэгдэхүүн болсон. Ёочингийн томьёологдсон байдалд задлан шинжилгээ хийж дараах үзүүлэлтийг гаргав Үүнд:

Хүснэгт 1. Ёочиндох аргын томьёологдсон байдал

№	Багшийн нэр	Хэвлэгдсэн	Цохилго	Нэр томьёо (тайлбар)	Төрөл зүйл	Тэмдэг тэмдэглэгээ
1	А.Чулуунбат (1969, 28)	1969	3	3	3	3
2	Г.Дашдаваа (1983, 9)	1983	4	4	4	4
3	Н.Жанцанноров ¹	1992	4	4	4	4
4	Ц.Саран (2006, 29, 49-67)	2006	39	19	39	20
5	С.Уранбилэг (2006, 73-80)	2006	35	11	36	=
6	Д.Чилхаасүрэн (2007, 13)	2007	25	25	25	25
7	Д.Лхагвасүрэн (Чилхаасүрэн, Номин-Эрдэнэ 2022, 61)	2007	5	=	5	5
8	Ц.Саран (2007, 10-12) ²	2007	5	5	5	=
9	Б.Бадарч (2009)	2009	23	23	23	23
10	С.Уранбилэг (2017, 276-281) ³	2017	14	14	53	32
11	С.Уранбилэг (2017, 322-323) ⁴	2018	22	22	29	4
12	Д.Лхагвасүрэн (Чилхаасүрэн 2022, 95-96)	2022	4	4	4	=

Ёочиндох аргын үндсэн баруун, зүүн цохилгыг А.Чулуунбат анх тэмдэглэсэн бөгөөд баруун гарыг [L], зүүн гарыг [J], хоёр гар зэрэг [U], дуржигнуулгыг [D] дүрсээр тус тус тэмдэглэжээ.

Үүнээс 25 жилийн дараа Г.Дашдаваа нь А.Чулуунбатын тэмдэглэсэн баруун, зүүн гарын тэмдэглэгээтэй санал нэгдсэн ч [L] дүрсээр тэмдэглэсэн дуржигнуулга цохилгыг нотны иш дээрх гурван зураасаар төлөөлүүлэн [𐎆] дүрсээр тэмдэглэгээ оноожээ. Харин баруун, зүүн гарын хамсрах цохилгыг [J] дүрсээр тэмдэглэжээ.

Мөн 2000-аад оны үед [L], [J], [U], [L] эдгээр дөрвөн тэмдэгтийг санал

¹ Жанцанноров Ёочин, үндэсний найрал хөгжимд зориулсан “Концерт” бүтээл

² 2007 онд дээрх үзүүлэлтээр баяжуулсан байна.

³ Шинэчлэн сайжруулсан.

⁴ Шинэчлэн сайжруулсан.

нэгтгэйгээр тэмдэглэсэн (Саран 2007, 10-12), (Соёл, урлаг судлалын хүрээлэн 2017, 276-281), (Бадарч, 2009) бол Д.Чилхаасүрэн нь янчиндах аргын тэмдэглэгээнд тулгуурлан баруун, зүүн гарыг [L], [R] хэмээн тэмдэглэжээ (Чилхаасүрэн, Номин-Эрдэнэ 2022, 61).

Ёочиндох арга барилын түүхийн явцаас үзэхэд, судлаач багш нар зарим цохилго дээр санал зөрөлдсөн ч баруун, зүүн гар тус тус, хоёр гараар ээлжлэн хөгжимдөх аргын [L], [R], [L R] эдгээр гурван тэмдэглэгээг орчин цагийн ёочинд зориулсан бүтээлүүдэд түлхүү ашиглах болжээ. Ингэхдээ энэхүү аргаар хөгжимдөх ардын арга барилыг “дан”, “задгай”, “давхар” хэмээн нэрлэж ирсэн түүхтэй.

Хүснэгт 2. Ардын уламжлалт арга



№	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	Дан	[L], [R], [L R]	Баруун, зүүн гар ээлжлэн цохих	үндсэн аялгууг өгөгдлийн дагуу хөгжимдөх
		Задгай		Үндсэн аялгууны хэмнэлийг нэг дахин хурдасган эгшиг хэмнэлээр баяжуулан жигд хүчээр саван хөгжимдөх	хагас нотыг 4-т, 4-тыг 8-т, 8-тыг 16-т г.м
		Давхар		Үндсэн аялгууны хэмнэлийг хоёр дахин (8-тыг 16-т, 16-тыг 32, 32-тыг 64-т г.м) хурдасган эгшиг хэмнэлээр баяжуулж тасралтгүй асар хурдтай цавчин хөгжимдөх	8-тыг 16-т, 16-тыг 32, 32-тыг 64-т г.м


Жижиг

1930-аад оны үед Д.Ишдулам дууны арван хүүхний чуулга байгуулан “Цагаан пансан алчуур” дууг ёочингоор ганцаар хөгжимдөн, арван дуучин нь дуулахын хамт цөөн тооны хөдөлгөөний үндсэн дээр бүжиглэдэг байсан (Саран 2006, 30) бол О.Дашдэлэг нь “Шивээ хиагт”, “Улаан туг”, “Пионерын дуу” хэмээх хувьсгалын дуу, “Гандий мод”, “Зуун лангийн жороо луус”, “Алиа саарал” гэх мэт ардын богино дууг ганцаар хөгжимдсөнийг суралцагчид нь сонсголоор сурдаг тухай түүний шавь нарын дурсамж яриаг тэмдэглэсэн (Дашдондог 1967) байдаг. О.Дашдэлэг нь 1962.03.18-нд МАД “Өөрийн нутаг”, 1964.02.25-нд МАД “Ян тайван гөөгөө”, “Хөх торгон цамц”-ыг тус тус монголын радиод хөгжимдөн бичүүлсэн нь “Алтан фонд”-д хадгалагдан үлдсэн байна. Үүнээс үзэхэд ёочингоор бусадтай хамсах, ганцаар хөгжимдөхдөө баруун, зүүн гар ээлжлэн “дан” болон “задгай” цохилгоор цохин хөгжимддөг байв.

Мөн ёочиндох аргын өөрчлөлт, шинэчлэлийн онцгой нэгэн дэвшил бол 1970-аад оноос манай алдарт, ахмад хөгжимчид ардын богино дууг бусадтай хамсран хөгжимдөх “Холбоо дуу”-ны донж маяг (*маниар*) юм. Энэхүү дууг хөгжимдөхдөө дууны утга агуулга, хөгжимдүүрийн онцлог донж маягт тулгуурлан өөр өөрийн сэтгэл мэдрэмж, арга барилаар хөгжимдөхдөө дан, задгай, цохилгоос гадна “давхар” цохилгыг ёочингийн цохилго хөдөлгөөнд шинээр нэвтрүүлсэн байдаг.






Зөвхөн ардын дуунд хэрэглэгдэх “давхар” цохилгыг эгшиг, хэмнэлээр баяжуулж, ёочинд зориулсан дан хөгжмийн бүтээлд анх нэвтрүүлсэн бүтээл бол 1971 онд зохиогдсон Ж.Мэнд-Амарын “Хөдөлмөрийн жавхаа” бүтээл юм.

Энэхүү цохилгыг тус бүтээлд баруун, зүүн гарын хамсрах хөдөлгөөнд тулгуурлан хүчтэй хувь дээр дөрвөн 16-тыг, хүчгүй хувь дээр 32-тын гуравлал () хэмнэлээр тусгасан байдаг. Энэхүү аргыг зохиогч өөрийн биеэр хөгжимдөхдөө дөрвөн 32-т орсон хэмнэлээр () баяжуулан нэг дахин хурдасгасан байна. Жишээлбэл:











Зураг 1. Ж.Мэнд-Амар “Хөдөлмөрийн жавхаа” (давхар цохилт)

Ёочиндох аргын өөр нэгэн өвөрмөц цохилго бол “дуржигнуулга” юм. Энэхүү цохилгыг дараах байдлаар нэрлэж, тэмдэг оноосон байна. Үүнд:

- ✓ “Дуржигнуулга” хэмээн нэрлэж, [], [//] тэмдэглэсэн
- ✓ “Чичиргээ” хэмээн нэрлэж [] тэмдэглэсэн
- ✓ “Торжигнох” хэмээн нэрлэж, [], [], [] тэмдэглэсэн зэрэг болно.

Ийнхүү судлаач багш нарын оноосон дуржигнуулга цохилгын нэршил, тэмдэглэгээнээс харахад өөр хоорондоо харилцан адилгүй байна.

Гэтэл 1984 онд оноосон Г.Дашдаваагийн тэмдэглэсэн [] дүрст тэмдэглэгээг зөвхөн ёочинд төдийгүй бусад улс орны ижил, төст хөгжимдүүрүүдэд ийнхүү тэмдэглэдэг.


Иймээс [] энэхүү тэмдэглэгээг баруун, зүүн гарын [], [], [] эдгээр дүрст тэмдэглэгээнд тулгуурлан [], [], [] гэж тэмдэглэх саналыг дэвшүүлээд байна.

Мөн бидний хэлж заншсан “третомо”-ийг анх 1996 онд хөгжмийн онолын үүднээс тодорхойлон, “дуржигнуулга” хэмээн нэрлэсэн (Жанцанноров 1996) бөгөөд үүнийг ёочиндох аргын томьёололд 2006 онд нэвтрүүлсэн (Саран 2007, 10-12).

Хүснэгт 3. Уламжлалт дуржигнуулга цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	<u>Дуржигнуулга</u>	[], [] []	Нэг буюу хос эгшигийг тасралтгүй давтамжаар асар хурдтай жигд үргэлжлүүлэн цохих	баруун, зүүн гар тус тус болон хоёр гар хамсран ээлжлэх
Жишээ	<p><i>дуржигнуулга</i></p> 				

Дуржигнуулгыг анх ёочинд зориулсан дан хөгжмийн бүтээлд тусгасан нь 1959 онд зохиогдсон Л.Мөрдоржийн “Хаврын шувууд ирлээ” ба ёочин, симфони найрал хөгжимд зориулсан анхны бүтээл юм. Энэхүү бүтээлийг Г.Дашдаваа үндэсний найрал хөгжимтэй гоцлон хөгжимдсөн (Чилхаасүрэн 2007, 29) түүхтэй.



Зураг 2. “Хаврын шувууд ирлээ” (оршил хэсэг)

Дуржигнуулга нь орчин цагийн урын санд “хулст”, “угсраа” хэмээх хоёр хувилбарт хэрэглэгдэх болсон.

Энэхүү цохилго нь анх янчин⁵-ы бүтээлээр дамжин ёочиндох аргад хэрэглэгдэх болсон бөгөөд үүнийг ёочинд зориулсан хэд хэдэн бүтээлд тусгасан байдаг.

Анх энэхүү цохилгыг Гуан-Дуны янчины урлагийг үндэслэгч Ян-Лоу-Ли нь “Сан Бао Фу” бүтээлийн ая аялгуунд тулгуурлан “Доу-Чуи-Лян” (он тодорхойгүй), “Лян Хуан Көү” хэмээх хоёр бүтээл, 1921 онд “Хан-Тян-Леи” хэмээх бүтээлүүдийг туурвихдаа дуржигнуулга цохилгыг “хулст дуржигнуулга” хэмээх өвөрмөц цохилгоор баяжуулжээ (Туяажин 2022, 48-49). Энэ нь цохиурыг хүчтэй савах явцад цохиурын толгой асар хурдтай туялзах чичиргээг чавхдасд хүргэн дуржигануулах арга бөгөөд үүнийг “#”, “+” (颤竹-*chan zhu*) хэмээн тэмдэглэжээ. Жишээлбэл:



Зураг 3. “Доу-Чуи-Лян” бүтээлийн “хулст дуржигнуулга” цохилго

Хулст дуржигнуулгаар баруун, зүүн гар тус тус болон хамсран хөгжимдөх бөгөөд дан эгшгийг дуржигнуулах явцад нөгөө гар дан эгшгээр хам эгшгийг цувуулан хөгжимдөх, хос эгшгийн угсарч дуржигнуулах хувилбаруудад хэрэглэдэг.

Энэхүү цохилгоор хөгжимдөхөд нимгэн иштэй цохиур сонгох бөгөөд маш уян байх шаардлагатай. Энэ агуулгын дор “хулст” хэмээн нэрлэсэн. Мөн үүнийг цохиурын толгой дээш, доош савах хөдөлгөөний дүрслэл уялдуулан [>], [>], [✕] хэмээн тэмдэглэсэн юм.

Хос эгшгийн зэрэг цохин хөгжимдөх аргыг дараах байдлаар томьёолжээ. Үүнд:

- ✓ “Зэрэгцүүлэн тоглох”, “зэрэг цохих” тайлбар нэр өгч, [□] тэмдэглэсэн
- ✓ “Хоёр гараар хос эгшиг дуурьсах” хэмээн тайлбарлаж, [1 1] тэмдэглэсэн
- ✓ “Зэрэг цохих” хэмээн тайлбарлаж, [✕] тэмдэглэсэн зэрэг болно.

Гэтэл анх ёочингийн томьёололд 2006 онд “хос цохилго” хэмээх нэр үг оноожээ (Саран, 2007, 10-12).

Мөн Г.Дашдаваа нь энэхүү цохилгод тайлбар нэр оноосон ч тэмдэглэхийн хувьд [□] хэмээн тэмдэг оноосон нь өнөөгийн сургалт, уран бүтээлд хэрэглэгдсээр байна.

⁵ Зүүн Азийн ёочин төст хөгжимдүүрийн нэгэн төрөл юм.

Хүснэгт 4. Хос цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	Хос	[Ш]	Хос эгшигийг зэрэг цохих (интервал)	баруун, зүүн гар зэрэг
Жишээ					

Ёочиндох аргын хамгийн өвөрмөц нэгэн цохилго бол баруун, зүүн гар хоёр өөр хэмнэлийг хамсран хөгжимдөх арга бөгөөд энэ нь 1980-аад оны ёочинд зориулсан бүтээлээс улбаатай юм.

Орчин цагт хөгжмийн зохиолч, уран бүтээлчид, ёочинчид нь зохиол бүтээлдээ энэхүү цохилгыг түлхүү тусгасаар ирсэн. Энэ нь ёочиндох арга цохилго хөдөлгөөнд 2006 онд “бутархай” цохилго хэмээн нэрлэгдэж (Саран 2007, 29, 49-67) байжээ.

Ёочиндох арга барилд хулсан цохиураас гадна модон цохиурыг хэрэглэх нь байдаг. Энэ цохиураар баруун, зүүн гар хамсран хөгжимдөхөөс гадна уламжлалт болон угсраа цохилгоор хөгжимдөх онцлогтой.

“Угсраа” дуржигнуулгыг хулст дуржигнуулгын тэмдэгтэд тулгуурлан [↖], [↗], [✱] хэмээн дүрт тэмдэглэгээ оноосон юм.

Хүснэгт 5. Хулст, угсраа дуржигнуулга

№	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	Хулст	[↗], [↗] [✱]	Цохиурыг хүчтэй савж, цохиурын толгойн туялзах асар хурдтай чичиргээг чавхдаст хүргэн дуржигнуулах	Баруун, зүүн гарын, дан, давхар эгшигт, цохилго, дуржигнуулга хосолсон.
		Угсраа	[↖], [↖] ✱	Цохилтын хүчний чавхдас дээрх ойлтоос гарах хөдөлгөөнөөр угсран дуржигнуулах	

Энэ удаа бид үүнийг баруун, зүүн гар хоёр өөр хэмнэлээр хамсран хөгжимдөх тохиолдолд ихэвчлэн үндсэн аялгуунд захиролжуулах (гармонизация) хам эгшигийг хамсран болон цувруулан хөгжимдөх зориулалттай. Үүнийг аялгуу даган хөгжимдөх аккомпанемент буюу “хамсраа” хэмээн тодорхойлсны (Жанцанноров 1996, 12) дагуу нэрлэж, тэмдэглэгээг хоёр өөр өгөгдлийг нэг дор хамсран хөгжимдөх агуулгын дор [↖] хэмээн дүрсэлж хамсран хөгжимдөх [⊥] тэмдэгтэй уялдуулан [✱] гэж тэмдэглэв.

Хүснэгт 6. Хамсрах цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	Хамсраа	[$\underline{\text{K}}$]	Хоёр өөр хэмнэлийг хамсран хөгжимдөх	баруун, зүүн гар
Жишээ					

Хамсраа цохилгыг анх ёочинд зориулсан бүтээлд тусгасан нь 1971 онд зохиогдсон Ж.Мэнд-Амарын “Хөдөлмөрийн жавхаа” бүтээл юм. Энэхүү бүтээлд хамсраа цохилгыг тусгахдаа аялгуунд зохиролжуулах (*гармонизация*) хам эгшгийг баруун гарт хуваарилан зүүн гарт аялгуу оноож хоёр гар хоёр өөр хэмнэлийг хамсран хөгжимдөх байдлаар тусгажээ.




Зураг 4. Ж.Мэнд-Амар “Хөдөлмөрийн жавхаа” (хамсраа цохилго)

Ёочиндох арга, цохилго хөдөлгөөний дэвшилд шинэчлэлийг авчирсан энэхүү бүтээл нь орчин цагийн ёочингийн сургалт, уран бүтээлд үнэ цэнтэй хэвээр бөгөөд анх 1972.08.19-нд зохиогч өөрийн биеэр монголын радиод хөгжимдөн бичүүлэн “Алтан фонд”-д хадгалуулан үлдээжээ.

Эгшигт зохицуулагдах хоёроос дээш хэмнэл (*8-т, 16-т, хоёрлол, гуравлал, тавлал г.м*)-ийг баруун, зүүн тус тус угсарч цохих үйлийг “угсраа” цохилго хэмээх бөгөөд энэ нь дан болон давхар эгшгийн хэмээн хоёр төрөлд ангилагдана. Үүнийг хөгжмийн бүтээлүүдэд ноотны иш дээр зураасаар тэмдэглэдэг жишгийн дагуу [t], [t], [t] хэмээн тэмдэглэв.

Хүснэгт 7. Угсраа цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	Угсраа	[t], [t], [t]	Хоёр өөр хэмнэлийг хамсрах	баруун, зүүн гар
Жишээ					

1970-1980-аад онд монголын хөгжмийн зохиолчид ёочингийн мэргэжлийн сургалт, уран бүтээлд шинээр бүтээл туурвих нь нэлээд хомс байсан тул гадаадын хөгжмийн зохиолчдын концерт, сонат, пьес, вальс гэх мэт дан хөгжмийн бүтээлүүдийг хөрвүүлэн, найруулах үйл ид өрнөж байв. Үүний үр дүнд ёочиндох арга барилд “угсраа”, “хос” өвөрмөц цохилгуудыг шинээр нэвтрүүлжээ.

“Цувраа” цохилго бол өрнийн сонгодог болон дорнын хөгжмийн бүтээлүүдэд

түлхүү хэрэглэгддэг бөгөөд ёочинд зориулсан Л.Мөрдоржийн “Хаврын шувууд ирлээ” бүтээлд анх тусгагдсан байдаг. Үүнийг хөгжмийн онолын үүднээс “цувраа” хэмээх нэрлэсэн (Жанцанноров 1996).

Цувраа цохилгын нэг төрөл болох “шудраа” цохилго нь ёочинд зориулсан дан хөгжмийн бүтээлд аливаа нэг зүйлийг авиа эгшгийн төлөөлүүлэн дуурайн дугаргах тохиолдолд хэрэглэгдэх цохилго юм.

Хүснэгт 8. Цувраа, шудраа цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	Цувраа		Хам эгшиг (<i>аккорд</i>)-үүдийг баруун, зүүн гарт хурднаар доороос дээш, дээрээс доош цувруулан цохих	баруун, зүүн гар
2		Шудраа		Хам эгшиг (<i>аккорд</i>)-үүдийг баруун, зүүн гарт хурднаар доороос дээш, дээрээс доош цувруулан цохиурын ишээр шудрах	
Жишээ					

Өгөгдсөн ая, аялгууг богино эгшиг хэмнэлээр чимэглэсэн нэг үенд хийх хугалаа (*фрощлаг*), жиргүүлэг (*трель*), жиргээ (*мордент*), багц эгшиг (*группетто*) зэргийг чимэглэн цохилго гэнэ.

Энэхүү цохилго нь өрнийн сонгодог хөгжмийн бүтээлд хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд ёочинд зориулсан дан хөгжмийн бүтээлүүдэд өнөөг хүртэл хэрэглэгдсээр иржээ. Үүнийг ноот бичлэгт тогтсон дүрст тэмдэглэлээр сонгодог хөгжмийн урлагт тэмдэглэж ирсэн уламжлалтай.

Хүснэгт 9. Чимэглэн цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Цохих	Чимэглэн		Аялгууны нэг үенд хийх хугалаа (<i>фрощлаг</i>), жиргүүлэг (<i>трель</i>), жиргээ (<i>мордент</i>), багц эгшиг (<i>группетто</i>) зэрэг богино эгшиг, хэмнэлээр чимэглэн хөгжимдөх	баруун, зүүн гар
Жишээ					

Ёочиндох хоёр дахь онцлог арга бол чавхдасыг хуруугаар, цохиурын ишээр татах болон чавхдасыг хуруу буюу аливаа зүйлээр дарж хөгжимдөх аргыг чавхдастай олон янзаар харьцан эгшиг гаргадаг агуулгын дор “чавхдаст цохилго” хэмээн нэрлэв.

Энэхүү аргыг судлаач багш нарын томъёолсноос авч үзэхэд, “пиццикато” (*pizzicato*, *хумс*) хэмээн нэрлэж [p-pizz], [p-pizz.p] ийн үсгэн тэмдэглэгээ оноосон


(Саран 2007, 10-12) бол “чанга буюу цохиурын сүүлээр татах” хэмээн тайлбар нэрээр [+] ийн тэмдэглэхдээ баруун, зүүн гарын хөдөлгөөнийг аяар өгсөх тэмдгийг [↗], аяар уруудах тэмдгийн [↘], хумсаар татах үйлийг [—] ийн тус тус тэмдэглэсэн (Чилхаасүрэн 2007, 13). Мөн энэхүү цохилгыг “Pizz” хэмээн нэрлэж, гараар болон цохиурын ишээр татаж хөгжимдөх хэмээн тайлбарлаж [✱], [↘] ийн тэмдэглэхийн хамт, хуруугаар татах, хумс болон хурууны өндгөөр авиа эгшиг гаргах хэмээх өөр нэгэн тайлбарыг дэвшүүлсэн бөгөөд үүнийг [∨] ийн тэмдэглэсэн (Бадарч, 2009) бол татах үйлийн “татах цохилго” хэмээн нэрлэхдээ [L], [L], [L] ийн тэмдэглэжээ (Уранбилэг 2017, 276-281).

Мөн энэхүү цохилгыг анх “цохиурын араар” хэмээн тайлбар үгээр нэрлэж [IIcollegno] ийн дүрст, үсгэн тэмдэглэгээ оноон тэмдэглэсэн (Саран 2007, 10-12) бол цохиурын сүүлээр татах хэмээх тайлбар нэршилтэй [+] хэмээх дүрст тэмдэглэгээтэй тэмдэглэгдэж (Чилхаасүрэн 2007, 13) байсан. Харин 2009 онд мөн л “цохиурын араар” нэршилээр [f], [j] хэмээх дүрст тэмдэглэгээгээр тэмдэглэжээ (Бадарч 2009). Гэтэл энэхүү цохилгыг цохиурын араар хэмээн тайлбарлаж байсныг “цохиурын иш” болгон нэрлэж, [P] хэмээх дүрст тэмдэглэгээгээр шинэчлэн тэмдэглэгджээ.

Энэ татах арга нь чавхдасыг дээш татан хөгжимдөх үйлийн дор чавхдасыг [—] ийн дүрст тэмдэглэгээ оноон чавхдасыг хуруугаар татах [—], хумсаар татах [↘], цохиурын ишээр татах [L] зэрэг үйлүүдэд тус тусын дүрст тэмдэглэгээ оноосон юм (Уранбилэг 2017, 276-281).

Мөн энэхүү татах цохилгын эсрэг хувилбар болох нэг гараар чавхдас болон тэвхийг дарж нөгөө гар нь чавхдасыг цохих, татах явцад олон янзын авиа дуурьсгах өвөрмөц онцлог бүхий цохилго юм.

Хүснэгт 10. Чавхдаст татах цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Дарах	Чавхдаст татах		Чавхдасыг хуруугаар, цохиурын ишээр татах	баруун, зүүн гар
Тайлбар	<p>Чавхдасыг дараах гурван аргаар татан хөгжимдөнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хуруугаар татах ✓ Хумсаар татах ✓ Цохиурын ишээр татах зэрэг болно. <p>Энэхүү гурван арга тус бүр дараах байдлаар зохицуулагдана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Баруун гар нэг буюу хэд хэдэн эгшгийг зэрэг буюу цувуулж татах - Зүүн гар нэг буюу хэд хэдэн эгшгийг зэрэг буюу цувуулж татах - Баруун, зүүн гар нэг буюу хэд хэдэн эгшгийг зэрэг татах - Баруун, зүүн гар нэг буюу хэд хэдэн эгшгийг цувуулж татах зэрэг болно. 				

Ёочиндох арга, цохилго хөдөлгөөнд янчины бүтээлээр дамжин хэрэглэгдэх болсон өвөрмөц нэгэн цохилго бол чавхдасыг дээрээс доош чигт дарж хөгжимдөх арга юм.

Энэхүү цохилго нь бүтээлийг утгажуулах, чимэх, уянгалуулах гэх мэт агуулга дор авиа эгшгийг зөөлрүүлэх, битүү авиа гаргах, эгшгийг чичрүүлэн хэлбэлзүүлэх гэх мэт олон янзаар хувирган илэрхийлэх онцлогтой бөгөөд энэ нь

найман хувилбараар баруун, зүүн гар тус тус болон ээлжлэн хөгжимдөх үйлээр тодорхойлогддог.

Энэхүү цохилгын томъёологдсон байдлаас үзэхэд, “исгэрүүлэх буюу хурууны өндгөөр тэвхэн дээр дарах” хэмээн тайлбарлаж [○] хэмээн тэмдэглэсэн, хуруугаар дарах [▶], цохиураар дарах [▷], цохиураар цохиод зүүн гараар дарах (*вибрация*) [⊥] зэрэг тайлбарт тэмдэглэгээ оноосон (Чилхаасүрэн 2007, 13) бол гараар дарах (*нидаль*) [*], өндгөөр тэвхэн дээр дарах [⊙] хэмээн тайлбарлаж тэмдэглэгээ оноосон бөгөөд “товшил цохилго” хэмээн нэрлэсэн. Битүү цохих (*цохиураар цохисон авиа эгшигийг хурууны өндгөөр дарах*) [○] хэмээн тайлбарлаж тэмдэг оноосон байна (Саран 2007, 10-12).

Дээрх судалгаанаас үзэхэд, энэхүү цохилгыг тайлбар нэрээр нэрлэж, тэмдэг тэмдэглэгээ оноосон нь өөр хоорондоо харилцан адилгүй, ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж, дээрх арга нь есөн хувилбартай болохыг тодруулан, чавхдаст цохилго хэмээн нэрлэж, тэдгээрийн онцлог, шинжийг тодорхойлон тэмдэглэгээ оноов.


Хүснэгт 11. Чавхдаст дарах цохилго

	Арга	Цохилго	Тэмдэг	Тодорхойлолт	Тайлбар
1	Татах	Чавхдаст дарах	☺	Чавхдасыг хуруугаар буюу бусад зүйлээр дарах	баруун, зүүн гар
Тайлбар	1.	Чавхдасыг хуруугаар дарж, эсрэг талыг цохин эгшигийг чичрүүлэх (<i>вебрация</i>)	⬇️		
	2.	Чавхдасыг хуруугаар дээш дарж, эсрэг талыг цохин эгшигийг дээшлүүлэх	⬆️		
	3.	Чавхдасыг хуруугаар доош дарж, эсрэг талыг цохин эгшигийг доошлуулах	⬇️		
	4.	Чавхдас дээр хурууны өндгөөр дарж / <i>чимхэх</i> / гулсуулан эгшиггаргах	☺		
	5.	Чавхдасыг хурууны өндгөөр дарж цохин эгшиг үүсгэх	☺		
	6.	Хурууны өндгөөр өнгөц дарж цохиурын араар татах	☺		
	7.	Цохилтгой хамт чавхдас дээр дарж исгэрүүлэг эгшиг гаргах (<i>фложлит</i>)	☺		
	8.	Чавхдас дээр дарж дуурьсах эгшигийг хаах	✳️		
	9.	Тэвх дээр дарж цохин битүү эгшиг гаргах	○		


Ёочингийн бүтэц, зохион байгуулалт, онцлог шинж чанар (*хөгжимдүүрийн эд хэрэгсэл*)-т тулгуурлан олон янзын үйл (*цохих, шудрах, чимхэх, татах, дарах, чавхдас, няслах г.м*)-ээр авиа, эгшиг дуурьсгаж бүтээлийн утга санааг илэрхийлэх, аливаа юмс үзэгдлийг дуурайлган элдэв дуу, авиа, чимээ гаргахад дэмжлэг болохуйц хэд хэдэн цохилгыг хөгжмийн зохиолчид, хөгжимчид нь бүтээлдээ тусган ёочингийн сургалт, уран бүтээлд нэвтрүүлэн шингээж хэрэгжүүлсээр ирсэн байдаг.

Энэхүү олон арван цохилгыг бид “чөлөөт цохилго” хэмээн нэрлэж төрөл зүйлсийг тус тус тайлбарлан тэмдэг оноосон билээ. Үүнд:

Хөгжимдүүрийн цар дээр морины алхаа гишгээг илэрхийлэхдээ цохиураар баруун, зүүн гар 8-т, 16-т хэмнэл болон түүнийг хоёр дахин хурдасган “давхар” цохилгоор товшин асар хурдтай цохин хөгжимдөж илэрхийлдэг. Энэхүү




цохилгыг “модон дээр тогших” тайлбартай [X], “товших цохилго” нэртэй [M], “цохиураар цар, модон дээр цохих” тайлбартай [□], “чөлөөт цохилго”-ын нэгэн төрөлд [┌] тэмдэгтээр тус тус тэмдэглэгээ оноосон байдаг. Харин модон дээр цохин хөгжимдөх үйлийн эгшиг бичлэгт [≡≡≡] хэмээн тэмдэглэдэг тул үүнийг [┌] цар дүрст тэмдэгтэй уялдуулан [┌] ийн тэмдэглэв.



Ёочингоор хөгжимдөхөд цохиурыг хэрэглэхээс гадна зарим туслах хэрэгсэл (бөгж, тулхүүр,

хуруу, хумс г.м)-ийг ашиглан өвөрмөц содон авиа, эгшгийг дуурьсагадаг. Үүний нэг нь тусгай зориулалтаар хийсэн бөгж юм. Чавхдас дээр бөгжөөр дарж цохих явцад дээш, доош гулгуулан эгшгийг хувиргах онцлогтой.

Ёочингийн бөгж, болон хөглөгч түлхүүрийг тодорхой бүтээлүүд дээр хэрэглэдэг, дамжуулан хэрэглэсэн байдаг.



Энэхүү цохилго нь янчины хөгжимдөх өвөрмөц цохилгын нэг болох бөгөөд үүнийг томьёололд “доороос дээш” (上滑抹) буюу [↗]

], “дээрээс доош” (下滑抹) буюу [↘], ”буцах” (回滑抹) буюу [↻] хэмээх дүрст тэмдгээр тэмдэглэгддэг бөгөөд ёочинд “бөгжөөр цохих” (тусгай зориулагдсан бөгжийг ашиглан олон янзын авиа эгшиг гаргах хэлбэр) хэмээх тайлбартай [↗] тэмдгээр тэмдэглэгдсэн бол энэ чиглэлээр бүтээл туурвисан зохиогч нь мөн янчины тэмдэглэгээг ашигласан байдаг.

Энэхүү цохилгыг гулгамтгай буюу [滑抹类] хэмээх нэрээр нэрлэсэн бол бид ёочингийн томьёололд “бөгжит” цохилго хэмээн нэрлэж янчины тэмдэглэгээгээр томьёолсон.



Үүний нэгэн адил ёочингийн хөглөгч түлхүүрээр чавхдасыг хүчтэй цохин гулгуулах явцад эгшиг хувиргах хувилбарыг анх 2009





онд [◦┌] хэмээх дүрст тэмдэглэгээг хэрэглэсэн байдаг. Мөн хөглөгчөөр цохих (хөглөгчийн ашиглан авиа эгшиг гаргах хэлбэр) хэмээх тайлбар үгээр нэрлэн [┌] ийн дүрст тэмдэглэгээ оноон тэмдэглэж байсан бол “түлхүүрт” хэмээн нэрлэн [┌] ийн дүрст тэмдэглэгээгээр тэмдэглэв.


Энэхүү цохилгын томьёоллын асуудал дээр судлаач багш нар нь зарим нэг өвөрмөц хувилбаруудыг томьёолсон ч тогтсон нэр нэршилгүй байдалд дүн шинжилгээ хийж энэхүү цохилгын олон арван хувилбаруудаас хөгжимчид чөлөөтэй сонголт хийн бүтээлийг илэрхийлдэг гэх утгаар “Чөлөөт цохилго” хэмээн нэрлэсний учир энэ бөгөөд эдгээр хувилбаруудыг тэр болгон томьёолох боломжгүй тул ёочиндох арга барилын эргэлтэд байнга хэрэглэгддэг цөөн хэдэн цохилгуудыг томьёолон нэгтгэхийн хичээлээ.


Мөн энэхүү цохилгыг хэрэгжүүлэх нэгэн гол хэрэглүүр бол хөгжимдүүр бөгөөд хөгжимдүүрийн эд, хэрэглэгдэхүүн бүрийг дараах байдлаар томьёолсон юм. Үүнд:


Цар мод: ёочингийн хөглөгч шон, тогтоогч шонг тоос шороо, эвдрэх эрсдэлээс хамгаалах мод. Энэ нь хөгжимдүүрийн хоёр талд байрлах таг бөгөөд цохиурын ишээр, хумсаар товшин цохиж, няслах зэргээр хөгжимддөг. Үүнийг [┌] хэмээх тэмдгээр тэмдэглэв.


Цохиур: Чавхдасыг цохин эгшиг гаргах хос мод. Энэ нь ёочингийн үндсэн хэрэглэгдэхүүн юм. Цохиур нь зөөлөвчтэй, зөөлөвчгүй байх бөгөөд цохиурын толгой, ишийг аль ч хувилбараар хэрэглэдэг. Үүнийг зөөлөвчтэй


[, зөөлөвчгүй [, цохиурын ар [, цохиурын иш [] хэмээх тэмдгээр тус тус тэмдэглэв.


Тэвх: Чавхдасыг цараас хөндийрүүлэн тэвхдэж эгшиг үүсгэх, чавхдасыг эгшгийн эгнээгээр дараалуулан байрлуулах зориулалт бүхий мод. Чөлөөт цохилго хийхэд тэвх дээр дарж битүү эгшиг үүсгэхэд хэрэглэдэг бөгөөд [] тэмдгээр тэмдэглэв.



Чавхдас: Эгшиг үүсгэх үүрэг бүхий уян хатан төмөр утас. Энэ нь зөвхөн эгшиг үүсгээд зогсохгүй чөлөөт цохилгод салхины исгэрээ, шувууны жиргээ, элдэв хийсвэр авиа эгшгээс гадна чахарсан муухай авиаг ч илэрхийлэхэд хэрэглэгддэг бөгөөд [] тэмдгээр тэмдэглэв.

Дэгээ: Чавхдасны нэг үзүүрийг гогодон тогтоох үүрэг бүхий тахийлгаж мурийлгасан хатуу металаар хийгдсэн дэгээ төмөр. Үүнийг чөлөөт цохилгод цохиурын араар цохих, шудрах явцад аливаа юмсыг тогших, тонших авиаг илэрхийлдэг бөгөөд [] тэмдгээр тэмдэглэв.

Бөгж: Тусгай зориулан бэлдсэн бөгжийг чавхдас дээр гулгуулан эгшгийг хэлбэлзүүлэх хэрэглэдэг бөгөөд үүнийг [] тэмдгээр тэмдэглэв.

Хуруу: Чавхдасыг зөвхөн цохиураар цохин хөгжимдөөд зогсохгүй хуруугаар дарах, татах, шудрах гэх мэт үйлээр царгиа, битүү, чичиргэл зэрэг авиа эгшгүүдийг гаргадаг бөгөөд [] тэмдгээр тэмдэглэв.

Хумс: Ятгын нэгэн адил хумсаар чавхдасыг татан хөгжимдөх аргад чөлөөт цохилго мөн хамрагддаг. Үүнд хумсаар чавхдасыг шудрах нь ус, далайн давлагаа, хүчтэй салхины исгэрээ гэх мэт чанга, ширүүн шинж чанарыг илэрхийлдэг бөгөөд үүнийг [] хэмээн тэмдэглэв.

Хязгаарлах тэмдэг: Энэ нь тухайн тэмдгийн эхлэх, дуусахыг тодорхойлсон тэмдэгт. Өөрөөр хэлбэл тухайн тэмдгийн оноосон хэсгээс дараагийн аль хэсэгт хүрэх зайг тодорхойлсон байдаг. Үүнийг [, ] хэмээх янчины тэмдэглэгээгээр тэмдэглэв.

Ийнхүү чөлөөт цохилгод хэрэглэгддэг хөгжимдүүрийн эд, хэрэглэгдэхүүнд тэмдэг оноосны учир бол хөгжмийн зохиолчид бүтээлийнхээ утга агуулгад тохируулан тэмдэглэгээг хийх боломжтой болно.

Хэлэлцүүлэг

Ёочиндох аргын томьёолол бол мэргэжлийн ухагдахууныг бүрэн дүүрэн илэрхийлэх үг буюу тэмдэглэсэн тэмдэглэгээ бөгөөд энэ нь мэргэжлийн уран бүтээлч, суралцагчдын хэрэгцээг хангах мэдээллийг агуулсан бичлэг юм. Өөрөөр хэлбэл, аливаа нэг бүтээлийн ая, аялгууны нугалаа, хугалаа, чимэглэлийг хэрхэн хөгжимдөх талаарх мэдээллийг агуулсан бичлэг юм.

Иймээс бид энэ талын эх хэрэглэгдэхүүнүүдтэй ажиллан тэдгээрийн ижил болон ондоолог тал, оноолтын оновчтой, оновчгүй байдлын ач холбогдолд ажиглалт, харьцуулалт хийж, томьёологдоогүй аргыг нэршүүлэн, тэмдэг тэмдэглэгээ оноож нэгдсэн томьёолохын зэрэгцээ ёочиндох аргыг төрөлжүүлэн ангилах тогтолцоог дараах байдлаар боловсруулан мэргэжил нэгт судлаачдаар хэлэлцүүлэн, зөвлөлдөж

ажилласан болно. Үүнд:

АРГА	ЦОХИЛГО	ТОДОРХОЙЛОЛТ	БАРИЛ	ТЭМДЭГЛЭГЭЭ	ТАЙЛБАР			
Цохиц	Дан	Дан, хос эгшигийг цохиц	Баруун гар	1. [L]	1. (Чулуунбат, 1969) (Уламжлалт ардын дуу, Бүхэнд зориулсан бүтээл) Зайлшгүй хэрэглэдэх үндсэн цохиц			
			Зүүн гар	2. [J]	2.			
			Баруун, зүүн гар ээлжлэн	3. [LJ]	3.			
	Задгай	Алгууны хэмнэлийг нэг дахин хурдастгаж эгшиг, хэмнэлээр бажуулан цохиц	2.	Баруун, зүүн гар ээлжлэн	4. [LJ]	4. (Дашдаваа, 1983, 9) (8m-ыг 8m, 8m-ыг 16m г.м) Ардын уламжлалт арга		
				Баруун, зүүн гар ээлжлэн	5. [LJ]	5. (8m-ыг 16m, 16m-ыг 32, 32m-ыг 64m г.м) Ардын уламжлалт арга		
	Хос	Хос эгшигийг зэрэг цохиц	4.	Баруун, зүүн гар	6. [L]	6. (Дашдаваа, 1983)		
				Угсрал	7. [LJ]	7. Баруун, зүүн гар тус тус угсарч цохиц		
	Хамсрал	Хоёр өөр хэмнэлийг багцлан хөгжимдөх	6.	Баруун, зүүн гар	10. [LJ]	10. Хоёр өөр хэмнэлийг баруун зүүн гар хамсран цохиц		
				Баруун, зүүн гар	9. [LJ]	9.		
	Дууныг дууна	Нэг буюу хэд хэдэн эгшигийг тасралтгүй дантамжтайгаар асар хурдтай үргэлжлүүлэн цохиц	7.	Баруун гар	11. [LJ]	11. Дан эгшигт, хос эгшигт ДАНГАЙН ЦОХИЦ		
				Зүүн гар	12. [LJ]			12.
				Баруун, зүүн гар ээлжлэн	13. [LJ]			13.
	Дууныг дууна	Хуягт	Цохиурыг хүчтэй саваа явцад цохиуран толгой асар хурдтай туклан чичрэх чичиргээг чихдэст хүргэн дуржигнуулах	Баруун гар	14. [L]	14. Уян хулан цохиуран толгой савагдах явцын чичиргээг ашиглах		
Зүүн гар				15. [L]	15.			
Баруун, зүүн гар ээлжлэн				16. [LJ]	16.			
Молоот		Цохиц явцад цохиуран толгой чихдэст дээрх ойлтоор дуржигнуулах	9.	Баруун гар	17. [L]	17. Хатуу модон цохиуран толгой савагдах явцын чичиргээг ашиглах		
				Зүүн гар	18. [L]			18.
Цохиоорт		Хам эгшигийн дууныг цулуулан цохиц	10.	Баруун, зүүн гар ээлжлэн	19. [L]	19. Дууныг дууныг доороос доош цулуулан цохиц		
				Баруун, зүүн гар ээлжлэн	20. [L]	20. Дууныг дууныг доороос доош цулуулан цохиц		
				Баруун, зүүн гар ээлжлэн	21. [L]	21. Дууныг дууныг доороос доош цулуулан цохиц		
				Баруун, зүүн гар ээлжлэн	22. [L]	22. Дууныг дууныг доороос доош цулуулан цохиц		
				Баруун, зүүн гар ээлжлэн	23. [L]	23. Цохиуран ишээр доороос доош		
Шуудан	Хам дууныг цулуулан шуудан	11.	Баруун, зүүн гар ээлжлэн	24. [L]	24. Цохиуран ишээр доороос доош			
			Баруун, зүүн гар ээлжлэн	25. [L]	25. Цохиуран ишээр баруун, зүүн гар хамсран доош, доош зөвчлэн			
			Баруун, зүүн гар ээлжлэн	22. [L]	22.			
Татах	Чавдасыг хуруугаар татах	12.	Баруун, зүүн гар зэрэг татах	23.	[L]	26. 1-6 эгшигийг 1-3 эгшигийг		
			Баруун, зүүн гар цулуулан татах	24.				
			Баруун гар зэрэг татах	25.				
			Баруун гар цулуулан татах	26.				
			Зүүн гар зэрэг татах	27.				
			Зүүн гар цулуулан татах	28.				
	Чавдасыг хумсаар татах	13.	Баруун, зүүн гар зэрэг татах	29.	[L]	27. 1-6 эгшигийг 1-3 эгшигийг		
			Баруун, зүүн гар цулуулан татах	30.				
			Баруун гар зэрэг татах	31.				
			Баруун гар цулуулан татах	32.				
			Зүүн гар зэрэг татах	33.				
			Зүүн гар цулуулан татах	34.				
Чавдасыг цохиуран араар татах	14.	Баруун, зүүн гар зэрэг татах	35.	[L]	28. 1-6 эгшигийг 1-3 эгшигийг			
		Баруун, зүүн гар цулуулан татах	36.					
		Баруун гар зэрэг татах	37.					
		Баруун гар цулуулан татах	38.					
		Зүүн гар зэрэг татах	39.					
		Зүүн гар цулуулан татах	40.					

⁶ Соёл, урлаг судлалын хүрээлэн. 2017. Ёочин хөгжмийн нэр томъёоны хэлэлцүүлэг, үр дүн. цуврал XXII бүтээлээс ёочиндох аргын ангилал, төрөл зүйлийн дэлгэрэнгүйг харж болно.

Дарах	Тэвхий эсрэг доош дарах	15.	Баруун, зүүн гар	41.		29.	Чавхдасыг доош дарж эгшигийг дээшлүүлэх	
	Тэвхий эсрэг дарсан чавхдасыг дээшлүүлэх		Баруун, зүүн гар	42.		30.	Цохих явцад тэвхий эсрэг хуруугаар дарсан чавхдасыг авч эгшигийг доошлуулах	
	Тэвхий эсрэг дарж чичрүүлэх		Баруун, зүүн гар	43.		31.	Цохих явцад тэвхий эсрэг чавхдасыг чичрүүлэн дарж эгшигийг хэлбэлзүүлэх	
	Битүү эгшиг үүсгэх		Баруун, зүүн гар	44.		32.	Цохилттой зэрэг чавхдас дээр дарж битүү эгшиг гаргах	
			Баруун, зүүн гар	45.		34.	Цохилттой хамт чавхдас дээр дарж илсгэрүүлэх эгшиг гаргах (<i>дээрэстийн</i>)	
	Эгшигийн хаах		Баруун, зүүн гар	46.		35.	Чавхдас дээр дарж дуудьсаж эгшигийг хаах	
	Цохиурын араар татах		Баруун, зүүн гар	47.		36.	Хурууны өндгөөр өнгөц дарж цохиурын араар татах	
	Чавхдасыг дарах		Баруун, зүүн гар	48.		37.	Чавхдас дээр хурууны өндгөөр дарж <i>Ачлэх</i> /гулсуулан эшиггаргах.	
Цохилттой зэрэг дарах	Баруун, зүүн гар	49.		38.	Чавхдасыг хурууны өндгөөр дарж цохин эгшиг үүсгэх			
Чөлөөт	Аяаг чөлөөтх аргууд	16.	Баруун, зүүн гар	50.		39.	Формлаг	Сөнгөлдөг хөгжмийн урлагаас улбаатай уламжлалт аргуу
						40.	Морзонг	
						41.	Группетто	
						42.	Трель	
Чөлөөт	Ёочингийн тэвх, шар, чавхдас, шон зэргийг ашиглан цохих, татах, дарах, гулгуулах, жудрах, чавхдах чивхэх зэрэг аргаар бүтээлийн утга санааг илэрхийлэхэд байгалийн болон амьтдын дуу чимээ, бороо, салхи, шуурга гэх мэт юмс үзэгдэлийг харьцуулж өнгө авс, чанга, сул хүчийг тодорхойлон дуурайлган хөгжимдөх аргууд	17	Цар мод	51.		43.	Модон дээр цохих, хумсаар товших	
			Цохиур	52.		44.	Хөгжимдүүрийн аль ч хэсэгт цохих	
			Зөөлөвчгүй цохиур	53.		45.	Хөгжимдүүрийн эгшиглээг өөрчлөх зориулалтаар цохиурын зөөлөвчийг авах	
			Цохиурын толгойн ар	54.		46.	Цохиурын араар цохин цангинасан эгшиг гаргах	
			Цохиурын иш	цохих	55.		47.	Цохиурын ишээр богино эгшиг гарган аялгууг чимэг
				татах	56.			
				шудрах	57.			
			Хөглөгч түлхүүр	58.		48.	Түлхүүрийн араар чавхдас дээр шудрах	
			Тэвх	59.		49.	Тэвх дээр дарж битүү эгшиг гаргах	
			Чавхдас	60.		50.	Чавхдас дээр элдэв зүйлээр дарж шудран эгшиг гарга	
			Чавхдас тогтоогч шон	61.		51.	Шонг цохиурын араар шудрах	
			Бөгж	62.		52.	Хуруундаа бөгж зүүн чавхдас дээр шударч эгшиг гаргах	
			Хуруу	63.		53.	Чавхдасыг дарах, татах	
			Хумс	64.		54.	Чавхдасыг дарах, татах	
			Гулсуулах	65.		55.	Чавхдасыг хуруугаар хумсаар чивхэн гулгуулж эгшиг гаргах	
			Шудрах	66.		56.	Хуруу, цохиурын ишээр дээш доош шудрах	
			Чавхдах	67.		57.	Хуруугаар ивслэх, татах	
Чивхэх	68.		58.	Чавхдасыг чивхэх				
Цохих	69.		59.	Цохих, товших				

Дүгнэлт

Судлаач багш, уран бүтээлчдийн мэдлэг, оюун, дадлага туршлага, хөгжимдөх арга барилд тулгуурлан боловсруулсан томьёоллыг задлан шинжилсний үр дүнд ёочиндох аргын 65 төрөл зүйлийг тодруулан тодорхойлж, үүнийг хөгжимдөх үйлээр нь цохих, татах, дарах, чөлөөт хэмээн ангилан, онцлогоор нь 18 төрөлжүүлж, нэр томьёо, тэмдэг тэмдэглэгээг шинээр болон шинэчлэн оноож томьёолсон.

Энэхүү судалгааны онол-арга зүйн ач холбогдол бол ая аялгууг дуурьсгах үеийн нугалаа, хугалаа, чимэглэлийг ёочингоор илэрхийлэн хөгжимдөх 65 аргыг төрөл зүйлээр нь ангилан томьёолж, тодорхойлсон нэгдсэн систем (тогтолцоо)-ийг буй болгосонд оршино.

Ёочиндох аргын ангиллын системийг боловсруулан ёочингийн судалгаа, сургалт, уран бүтээлийн эргэлтэд оруулсанд судалгааны практик ач холбогдол нь оршино.

Ингэснээр, ёочинд зориулсан бүтээл, өрнийн болон дорнын хөгжмийн бүтээл, уламжлалт ардын арга барилаар хөгжимдөхөд мэргэжлийн ухагдахууныг бүрэн

дүүрэн илэрхийлэх томъёололтой, ёочиндох аргын тодорхой горим, тогтолцоотой болсноороо тухайн салбарт оруулж буй хувь нэмэр нь чухал ач холбогдолтой юм.

Судалгааны эцсийн үр дүнгээс үзэхэд, орчин цагийн ёочиндох аргын төрөл зүйлийг өнөөгийн байдлаар хязгаарлашгүй юм. Ёочинг хөгжимдүүр талаас, хөгжимдөх үйлийг донж маяг, онцлог талаас нь илүү дэлгэрэнгүй судалж, илүү ихийг эрэлхийлэн илрүүлж, баяжуулах боломж, хөгжмийн зохиолч, уран бүтээлчидтэй нягт холбоотой ажиллах, ёочингийн болоод хөгжимдөх аргын онцлогийг бүрэн илэрхийлж чадахуйц өвөрмөц бүтээлийг бүтээн туурвих цаг бидний өмнө өнөө хэр нээлттэй байна.

Ашигласан материалын жагсаалт

- Бадарч, Бат-Орших. 2009. “Ёочингоор өрнө, дорны хөгжмийн бүтээлийг хөгжимдөхүй.” Магистрын судалгааны ажил., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Дашдаваа, Гүнчин. 1983. *Ёочингийн сурах бичиг*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Дашдондог, Самдан. 1967. “Монголын театрын түүхийн тухай товчхон.” *Соёл утга зохиол* №17.
- Жанцанноров, Нацаг. 1996. *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй толь*. Улаанбаатар: ШУА-ийн Информатикийн хүрээлэн.
- Саран, Цэвэлмаа. 2006. *Ёочингийн сурах*. Улаанбаатар: Хөх судар принтинг.
- Саран, Цэвэлмаа. 2007. *Ёочин хөгжмийн гарын авлага*. Улаанбаатар: ЗДМ принтинг.
- Соёл урлагийн их сургууль. 2020. *Соёл урлагийн тайлбар толь, Боть IV: Хөгжим*. Улаанбаатар: Тод үсэг. BIBLIOGRAPHY \1 1104
- Туyajин, Норовням. 2023. “Тоцолбор бүтээл янчины уран бүтээлийн төрөл болох нь.” Магистрын судалгааны ажил., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Уранбилэг, Самдансүрэн. 2006. “Ёочингийн мэргэжлийн сургалт, хөг хөглөгөөний асуудал.” Магистрын судалгааны ажил., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.
- Уранбилэг, Самдансүрэн. 2017. “Ёочин хөгжмийн нэр томъёоны хэлэлцүүлэг, үр дүн.” Монголын соёл, урлаг судлал 22: 276-281.
- Чилхаасүрэн, Дугарсүрэн. 2007. *Ёочингоор хөгжимдөхүй*. Улаанбаатар: Арилдал.
- Чилхаасүрэн, Дугарсүрэн. 2022. *Эгшиглэнт ёочин минь*. Улаанбаатар.
- Чилхаасүрэн, Д., Номин-Эрдэнэ, Д. 2022. *Монголын хөгжмийн зохиолчдын ёочинд зориулсан бүтээлийн цомирлог-III*. Улаанбаатар: Үсэг хэвлэлийн газар.
- Чулуунбат, А. 1969. *Ёочиндож суръя*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.